

Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний 2025 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн 9/А дугаартай тогтоолын 2 дугаар хавсралт

ДҮҮРГИЙН ЭРҮҮ, ИРГЭНИЙ ХЭРГИЙН ХЯЛБАР АЖИЛЛАГААНЫ АНХАН ШАТНЫ ТОЙРГИЙН ШҮҮХЭД ИРГЭНИЙ ХЭРЭГ, НЭХЭМЖЛЭЛ, ГОМДОЛ, ХҮСЭЛТ, ДААЛГАВАР ХҮЛЭЭН АВАХ, ХУВААРИЛАХ, ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ШҮҮГЧ, ШҮҮХ БҮРЭЛДЭХҮҮНИЙГ ТОМИЛОХ НАРИЙВЧИЛСАН ЖУРАМ

I ХЭСЭГ. Нийтлэг үндэслэл

Нэгдүгээр зүйл. Журмын зорилго, үйлчлэх хүрээ

1.1 Энэ журмаар шүүхэд хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт, даалгавар хүлээн авах, хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой бусад ажиллагааг шүүгчид хуваарилах, хэрэг, гомдол, хүсэлтийг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүний сугалааг зохион байгуулахтай холбоотой харилцааг зохицуулна.

1.2 Шүүхэд хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах, тэдгээрийг хуваарилах, хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг томилохдоо “Иргэний хэргийн хөдөлгөөний аргачлал”, “Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нийтлэг журам” /цаашид нийтлэг журам гэх/-ыг баримтлан “Иргэн-2014” нэгдсэн системд урьдчилж сугалсан сугалааны дарааллаар мэдэх боломжгүй, санамсаргүй тохиолдлоор хуваарилна.

1.3 Энэ журмаар нарийвчлан зохицуулаагүй эсхүл журмыг тайлбарлан хэрэглэхэд эргэлзээ үүссэн тохиолдолд, мөн шүүгч, хэргийн оролцогчдоос маргаан гарсан тохиолдолд хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт, даалгаврыг хуваарилахдаа тухайн шүүгч өөрөө шийдвэрлэх, анх хуваарилагдсан шүүгчид харьяалуулан шийдвэрлүүлэх, шүүгчийг солихгүй байх, хэрэг шилжүүлэхгүй байх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үр ашигт байдлыг болон санамсаргүй тохиолдлыг харгалзах зарчмуудыг удирдлага болгож хэрэглэх буюу шийдвэрлэнэ.

Хоёрдугаар зүйл. Хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хуваарилах, хэрэг хянан шийдвэрлэх бусад ажиллагааг шүүгчид хуваарилах, хэрэг, маргаан хянан шийдвэрлэх шүүгч болон шүүх хуралдаан даргалагчийн дарааллыг тогтоох нийтлэг аргачлал, баримтлах зарчим

2.1 Хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт, даалгаврыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /цаашид “ИХШХШТХ” гэх/ болон Иргэний хэргийн хөдөлгөөний нийтлэг аргачлал, Нийт шүүгчдийн чуулганы 2021 оны 05 дугаар тогтоолыг баримтлан “Иргэн-2014” нэгдсэн системээс шүүгч нарт “тойрог дотор санамсаргүй тохиолдлын аргаар”, “системээс болон гараар” гэсэн аргачлалуудаар хуваарилах бөгөөд тайлангийн жил бүрийн эхэнд Шүүгчдийн зөвлөгөөнөөр шүүгчдийн нэрсийн дарааллыг сугалаагаар тогтоож, Иргэн-2014 нэгдсэн системд байршуулж тойрог үүсгэнэ.

2.2 Энэ журмын 2.1-д зааснаар шүүгчдийн нэрсийг сугалаагаар тогтоосон дарааллын дагуу “Иргэн- 2014” нэгдсэн системд байршуулах ажиллагааг шүүхийн Тамгын газрын дарга, Хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтсийн дарга, Ерөнхий

шүүгчийн туслах, танхимын тэргүүн туслах нарын хяналт дор тус шүүхийн Мэдээлэл технологийн мэргэжилтэн гүйцэтгэж тэмдэглэл хөтлөн баримтжуулж архивлана.

2.3 Шүүхэд хүлээн авч байгаа нэхэмжлэл, гомдол, хүсэлт, хэргийг шүүхийн мэдээлэл лавлагааны мэргэжилтэн ИХШХШТХ-ийн 62 дугаар зүйлд заасан бүрдүүлбэрийг шалгаж, ирсэн цаг, минутын дарааллаар хүлээн авсан тэмдэглэгээ хийж холбогдох бүртгэлийн дэвтэрт бүртгэж хуваарилагдсан шүүгчид хүлээлгэн өгнө. Хүндэтгэн үзэх шалтгаанаар шүүгчид хүлээлгэн өгөх боломжгүй бол шүүгчийн туслахад гарын үсэг зуруулж хүлээлгэн өгнө.

2.4 Хэрэг, нэхэмжлэл, гомдол, сөрөг нэхэмжлэл, хүсэлтийг хүлээн авах, хуваарилахдаа, мөн хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар тогтоохдоо дүрс бичлэг хийж 7 хоног бүр хадгалах төхөөрөмжид /CD, DVD, флаш диск, хард гэх мэт/ хуулбарлан хадгалах ба түүнд Тамгын газрын дарга тогтмол хяналт тавьж ажиллана.

2.5 Энэ журмын Хоёрдугаар зүйлийн 2.1-д заасны дагуу хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хүлээн авсан шүүгч шүүх хуралдааныг даргалах бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаан даргалагч болон шүүх бүрэлдэхүүнийг Ерөнхий шүүгч, түүнийг эзгүйд орлох танхимын тэргүүн, томилсон шүүгч захирамж гаргаж албажуулна. */Тус шүүхийн 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 11/А шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор өөрчлөн найруулсан/*

Гуравдугаар зүйл. Нэр томьёо

3.1 “нэхэмжлэл” гэж Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-12.1.5 дахь хэсэгт заасан нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг

3.2 “хүсэлт” гэж шүүх бүрэлдэхүүн буюу шүүгчийг татгалзан гаргах, гомдол гаргах хугацаа сэргээлгэх, давж заалдах журмаар гомдол гаргахад төлөгдөх тэмдэгтийн хураамжтай холбоотой хүсэлт, шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг илт үндэслэл муутай гэж гаргасан хүсэлт, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах, шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх хүсэлт, эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэй байгуулсан эвлэрлийн гэрээг баталгаажуулах, шүүхийн даалгавар гүйцэтгүүлэх хүсэлт болон бусад хүсэлтийг. */Тус шүүхийн 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 11/А шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор өөрчлөн найруулсан/*

3.3 “гомдол” гэж шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол, шийтгэврийг эс зөвшөөрч тухайн шатны шүүхэд бичгээр гаргасан гомдлыг,

3.4 “хэрэг” гэж давж заалдах шатны шүүхээс шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож дахин шийдвэрлүүлэхээр буцаасан хэрэг, шүүгчийг татгалзан гаргасан, адил шатны өөр шүүхээс шилжүүлсэн, харьяалал тогтоолгон ирүүлсэн болон тус шүүхийн Шүүгчдийн зөвлөгөөнөөс дахин хуваарилсан иргэний хэргийг,

II ХЭСЭГ. Хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт, даалгавар болон бусад ажиллагааг хуваарилах

Дөрөвдүгээр зүйл. Нэхэмжлэл хуваарилах

4.1 Дор дурдсан тохиолдолд нэхэмжлэлийг шүүгч нарт системээс, тойрог

дотор, санамсаргүй байдлаар хуваарилна.

4.1.1 Шүүхэд шинээр ирж буй нэхэмжлэл,

4.1.2 Өмнө нь шийдвэрлэсэн шүүгч тус шүүхэд ажиллахгүй болсон буюу өндөр насны тэтгэвэрт гарсан, сэлгэн ажилласан болон өвчтэй, чөлөөтэй, ээлжийн амралттай, сургалттай байгаагийн улмаас болон бусад үндэслэлээр нэхэмжлэл хүлээн авах боломжгүй бол нэхэмжлэлийг бусад шүүгчдэд,

4.1.3 Нэхэмжлэлийг хүлээн авч иргэний хэрэг үүсгэхээс өмнө шүүгч өөрөө татгалзан гарах хүсэлт гаргасныг Ерөнхий шүүгч хүлээн авсан бол тухайн шүүгчийг тойргоос гарган, бусад шүүгчид сугалааны дарааллаар, гараар тухайн нэхэмжлэлийг хуваарилан шилжүүлнэ.

4.1.4 Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан, хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн, нэхэмжлэлийг буцаасан, нэхэмжлэлээ татан авсан нэхэмжлэлийг хожим шүүх хүлээн авч хуваарилахдаа өмнө шийдвэр гаргасан шүүгчээс өөр шүүгчид системээс хуваарилагдсан нь мэдэгдвэл тухайн нэхэмжлэлд иргэний хэрэг үүсгэхээс өмнө урьд шийдвэр гаргасан шүүгчид мэдээлэл лавлагааны ажилтнаар дамжуулан системээр шилжүүлж өгнө.

4.2 Дор дурдсан тохиолдолд нэхэмжлэлийг шүүгч нарт системээс гараар хуваарилна.

4.2.1 Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан, хэргийг хэрэгсэхгүй болгосон, нэхэмжлэлийг буцаасан, нэхэмжлэгч нь нэхэмжлэлээ татан авсны дараа нэхэмжлэгч уг нэхэмжлэлээ дахин гаргасан тохиолдолд урьд хүлээн авсан шүүгчид системээс гараар хуваарилна. Нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагаа нэмэгдүүлсэн, өөрчилсөн, багасгасан, тодруулсан, хамтран нэхэмжлэгч, хариуцагч нэмэгдсэн, нэхэмжлэгч, хариуцагч хасагдсан, хүлээн авахаас татгалзсан захирамжид заасан зөрчлийг арилгасан зэрэг тохиолдолд урьд хүлээн авсан шүүгчид системээс тойрогт оруулахгүйгээр хуваарилна.

4.2.2 Нэг нэхэмжлэлийг хоёр буюу түүнээс дээш шүүгч хүлээн авахаас татгалзсан бол нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан сүүлийн шүүгчид хуваарилна.

4.2.3 Тодорхой иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэргийн оролцогчоос гаргасан сөрөг нэхэмжлэлийг тухайн хэргийг хянан шийдвэрлэж буй / шийдвэрлэсэн/ шүүгчид гараар хуваарилна.

4.2.4 Шүүхэд ирсэн шүүн таслах ажиллагаатай холбоотой бичиг хэрэг, өргөдөл гомдол, хүсэлт, хугацаа сэргээлгэх хүсэлтийг харьяалах танхимын тэргүүний туслах хүлээн авч, ирсэн цаг, минутын дарааллаар хүлээн авсан тэмдэглэгээ хийж, эрүүгийн бүртгэл хяналтын нэгдсэн системд, бүртгэлийн дэвтэрт бүртгэн Танхимын тэргүүн шүүгчид хуваарилна.

4.2.5 Хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоогүй бичиг хэрэг, өргөдөл гомдол, хүсэлт, Ерөнхий шүүгчид гаргасан гомдлыг Ерөнхий шүүгчийн туслах хүлээн авч, ирсэн цаг, минутын дарааллаар хүлээн авсан тэмдэглэгээ хийж, бүртгэлийн дэвтэрт бүртгэн, Ерөнхий шүүгч шүүгчид хуваарилна.

Тавдугаар зүйл. Хэрэг хуваарилах

5.1 Дараах тохиолдолд хэргийг шүүгчид системээс, тойрог дотор, санамсаргүй байдлаар хуваарилна.

5.1.1 Адил шатны шүүхээс шилжиж ирсэн болон дээд шатны шүүхээс харьяалал тогтоосон хэргийг системээс тойрог дотор санамсаргүй аргаар хуваарилна.

5.2 Дараах тохиолдолд хэргийг системээс гараар хуваарилна. /иргэний хэргийн нэгдсэн систем тойрог дотор санамсаргүй тохиолдлоор хуваарилах техникийн нөхцөл бүрдэх хүртэл хугацаанд./ */Тус шүүхийн 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 11/А шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор өөрчлөн найруулсан/*

5.2.1 Давж заалдах шатны шүүхээс шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож дахин шийдвэрлүүлэхээр буцаасан хэргийг тухайн хэргийг шийдвэрлэсэн шүүгчид хуваарилахгүй. Хэргийг сугалаагаар сугалсан нэрсийн дарааллаар хуваарилахад шийдвэрлэсэн шүүгчид таарвал алгасаж, дараагийн шүүгчид хуваарилна. */Тус шүүхийн 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 11/А шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор өөрчлөн найруулсан/*

5.2.2 Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлд зааснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас шүүгчийг татгалзан гаргасан хэрэг, */Тус шүүхийн 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 11/А шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор өөрчлөн найруулсан/*

5.2.3 Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянаад хүчингүй болгосон тохиолдолд уг хэргийг шийдвэрлэсэн шүүгчид хуваарилна. Хэргийг шийдвэрлэсэн шүүгч тухайн шүүхэд ажиллахгүй болсон тохиолдолд хүсэлтийг шийдвэрлэсэн шүүх бүрэлдэхүүн болон энэ журамд зааснаар хэрэг хуваарилахгүй байгаа шүүгчээс бусад тойрог дотор сугалаагаар сугалсан нэрсийн дарааллаар хуваарилна. */Тус шүүхийн 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 11/А шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор өөрчлөн найруулсан/*

5.2.4 Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74, 106 дугаар зүйлд зааснаар гаргасан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг мөн хуулийн 124 дүгээр зүйлд зааснаар хүчингүй болгосон тохиолдолд уг хэргийг тухайн захирамж гаргасан шүүгчид хуваарилна. */Тус шүүхийн 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 11/А шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор өөрчлөн найруулсан/*

5.2.5 Өөр шүүхэд шилжүүлсэн хэргийг буцаан шилжүүлсэн, дээд шатны шүүхээс харьяаллын маргааныг шийдвэрлэж ирүүлсэн хэргийг өмнө хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байсан шүүгчид системээс гараар хуваарилна. */Тус шүүхийн 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 11/А шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор өөрчлөн найруулсан/*

5.2.6 Тухайн шүүхэд ажиллахгүй болсон шүүгчийн захирамж /хэргийг хэрэгсэхгүй болгосон, нэхэмжлэлийг буцаасан/-ийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлд зааснаар хянан хэлэлцээд хүчингүй болгосон, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлийн 74.2, 106 дугаар зүйлийн 106.5 дахь заалтыг баримтлан хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн шийдвэрийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай

хуулийн 124 дүгээр зүйлийн 124.1 дэх хэсэгт зааснаар хүчингүй болгосон бол хэргийг сугалаа сугалж хуваарилна. Хэргийн сугалааг сугалахдаа Монгол Улсын шүүхийн тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн 72 дугаар зүйлийн 72.1.10-т зааснаар чөлөөтэй байгаа шүүгчийн нэрийг сугалаа сугалах нэрсийн жагсаалтаас хасна. Тойрог бүрэн дууссан тохиолдолд тойргийг дахин шинээр эхлүүлж сугалааг сугална. */Тус шүүхийн 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 11/А шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор өөрчлөн найруулсан/*

5.2.7 */Тус шүүхийн 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 11/А шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор хассан/*

5.2.8 Нэхэмжлэлийг Танхимын тэргүүнд 1 тойрог алгасаж хуваарилна. */Тус шүүхийн 2025 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн 12/А шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор нэмэлт оруулсан/*

Зургадугаар зүйл. Хүсэлт, даалгавар хуваарилах

6.1 Дараах тохиолдолд хүсэлт, даалгаврыг системээс санамсаргүй байдлаар хуваарилна.

6.1.1 Шүүхийн даалгавар гүйцэтгүүлэх, нотариатын мэдэгдэх хуудас баталгаажуулах, арбитрын шийдвэр баталгаажуулах хүсэлт, улсын тэмдэгтийн хураамж буцаан гаргуулах хүсэлт, шийтгэвэр баталгаажуулах хүсэлт, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас ирүүлсэн хүсэлт, эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр байгуулсан эвлэрлийн гэрээг баталгаажуулах хүсэлтийг Ерөнхий шүүгчид хуваарилахгүй ба бусад шүүгч нарт системээс тойрог дотор санамсаргүй аргаар хуваарилна.

6.1.2 Дээрх хүсэлт, даалгаврыг шүүхэд дахин гаргасан тохиолдолд өмнө нь шийдвэрлэсэн шүүгчид системээс гараар хуваарилна. Өмнө шийдвэрлэсэн шүүгч өвчтэй, чөлөөтэй, сургалттай, ээлжийн амралттай байгаагийн улмаас хүсэлт, даалгаврыг хүлээн авахгүй байх хугацаанд энэ журамд зааснаар шүүгчид системээс тойрог дотор санамсаргүй аргаар хуваарилна.

6.1.3 Гадаад улсын болон дотоодын шүүхээс даалгавар гүйцэтгүүлэх хүсэлтийг нэгдсэн системээс тойрог дотор санамсаргүй тохиолдлын аргаар шүүгч нарт хуваарилна.

6.1.4 Шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх хүсэлтийг тухайн хэргийг хянан шийдвэрлэсэн шүүгчид, тухайн шүүгч энэ журамд зааснаар хүсэлт хүлээн авахгүй байгаа эсхүл тус шүүхэд ажиллахгүй болсон тохиолдолд бусад шүүгч нарт тойргоор хуваарилна.

6.2 Дараах тохиолдолд хүсэлт, даалгаврыг системээс гараар хуваарилна.

6.2.1 Тухайн шатны шүүхэд гомдол гаргах болон давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах хугацаа сэргээлгэх хүсэлт, улсын тэмдэгтийн хураамжийг хойшлуулах, чөлөөлүүлэх хүсэлтийг тухайн хэргийг хянан шийдвэрлээгүй шүүгчид шүүгчдийн сугалсан сугалааны дарааллаар системээс гараар хуваарилна. Шийдвэрлэсэн хүсэлтийг шүүхэд дахин гаргасан тохиолдолд өмнө нь шийдвэрлэсэн шүүгчид системээс гараар хуваарилна. /иргэний хэргийн нэгдсэн систем тойрог дотор санамсаргүй тохиолдлоор хуваарилах техникийн нөхцөл бүрдэх хүртэл хугацаанд/

Долдугаар зүйл. Гомдол хуваарилах

7.1 Шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол, шийтгэвэрт гаргасан гомдол, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах тухай хүсэлтийг тойргийн журмаар нэрсийн дарааллаар гараар хуваарилна.” гэснийг “Шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол, шийтгэвэрт гаргасан гомдол, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулах тухай хүсэлтийг Иргэний хэргийн танхимын тэргүүнд, танхимын тэргүүний хянан шийдвэрлэсэн хэрэгт гаргасан гомдол хүсэлтийг тойргийн журмаар нэрсийн дарааллаар гараар хуваарилна. */Тус шүүхийн 2025 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн 12/А шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор өөрчлөн найруулсан/*

Наймдугаар зүйл. Гомдол, хүсэлт хянан шийдвэрлэх шүүх хуралдаан даргалагчаас бусад бүрэлдэхүүнийг сонгох

8.1 Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлд заасан гомдол /цаашид гомдол гэх/, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг хянуулах хүсэлт /цаашид хүсэлт гэх/ болон хэргийг шийдвэрлэх шүүх хуралдаан даргалагчаас бусад бүрэлдэхүүн /цаашид бүрэлдэхүүн гэх/-ийг сонгох сугалааг гараг харгалзахгүй явуулна.

8.2 Бүрэлдэхүүн сонгох сугалааг явуулахдаа тухайн шүүхэд ажиллаж байгаа иргэний хэрэг хянан шийдвэрлэж байгаа нийт шүүгчийг нэг тойрогт тооцож сугалаа явуулна.

8.3 Бүрэлдэхүүнийг сугалахдаа гомдол хүсэлт болон хэрэг хуваарилагдсан шүүгчийг, тухайн гомдол хүсэлт хэргийг өмнө нь шийдвэрлэсэн шүүгчийг болон шүүх бүрэлдэхүүнийг, мөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлд зааснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас хэргийн оролцогчийн болон өөрийн хүсэлтээр татгалзан гарсан шүүгч, өвчтэй, чөлөөтэй, сургалттай /шүүхийн нийт шүүгчид оролцох хөтөлбөрт сургалт болон тухайн шүүгч өөрөө бие даан албан бусаар оролцохоос бусад/, ээлжийн амралттай байгаа шүүгч, тойргоос өмнө сугалагдсан шүүгчийн нэрийг тус тус сугалаа сугалах нэрсийн жагсаалтаас хасна. Тойрог бүрэн дууссан тохиолдолд тойргийг дахин шинээр эхлүүлж сугалааг сугална

8.4 Шүүх хуралдаан хойшилсон нь шүүгч, шүүх бүрэлдэхүүн өөрчлөгдөх үндэслэл болохгүй. Томилогдсон шүүгч, шүүх бүрэлдэхүүн өвчтэй, чөлөөтэй, сургалттай, ээлжийн амралттай зэрэг хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас шүүх хуралдаанд оролцох боломжгүй болсон тохиолдолд бүрэлдэхүүний сугалааг дахин зохион байгуулна.

8.5 Бүрэлдэхүүнд сугалагдсан шүүгч тус шүүх хуралдаанд оролцох боломжгүй болсон /сургалтад хамрагдах, эмнэлэгт хэвтэх, чөлөө авах гэх мэт/ талаарх хүсэлтээ шүүх хуралдаан болохоос өмнө буюу дахин бүрэлдэхүүн сугалах боломжит хугацаанд Ерөнхий шүүгч, Танхимын тэргүүнд мэдэгдэж, танхимын тэргүүний туслах болон Хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтсийн дарга нь даргалагч шүүгчийн туслахад мэдэгдсэнээр бүрэлдэхүүний сугалааг дахин зохион байгуулна. */Тус шүүхийн 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 11/А шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор өөрчлөн найруулсан/*

8.6 Бүрэлдэхүүнд сугалагдсан шүүгч өвчтэй, чөлөөтэй, сургалттай зэрэг хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас улмаас өөр шүүгчийг нөхөн сугалсан тохиолдолд эзгүй байсан шүүгчийн нэрийг тойрогт дахин оруулна.

8.7 Бүрэлдэхүүн сонгох сугалааг тухайн гомдол, хүсэлт хуваарилагдсан шүүгчийн туслах сугалах бөгөөд, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга болон Тамгын газрын 1 ажилтныг оролцуулна.

8.8 Гомдол, хүсэлт хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнийг сугалахдаа тухайн захирамж /шийтгэвэр/, тогтоол, шийдвэр гаргасан шүүгч, шүүх бүрэлдэхүүний нэрийг хасаж, үлдэх шүүгч нарын нэрсээс сугална.

8.9 Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.6-д заасны дагуу адил шатны шүүхэд сэлгэн ажиллахад энэ журмын дагуу шүүх бүрэлдэхүүнийг сонгоно.

8.10 Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.6-д заасны дагуу адил шатны өөр шүүхээс шүүх бүрэлдэхүүн ирүүлэх тохиолдолд энэ журам хамаарахгүй.

8.11 Хэрэг, гомдол, хүсэлтийг бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэх шүүх хуралдааныг 7 хоног бүрийн Пүрэв гарагт товлох бөгөөд бүрэлдэхүүний шүүгчтэй зөвшилцсөн бол бусад гарагт товлож болно.

Есдүгээр зүйл. Хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт, даалгавар
хуваарилалтыг түр зогсоох

9.1 Шүүгч ажлын тав хоног дотор эмчийн магадалгаатай болон Ерөнхий шүүгчийн захирамжаар чөлөөтэй байгаа тохиолдолд нэхэмжлэл, хүсэлт, хэрэг, даалгаврыг зогсохгүй. */Тус шүүхийн 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 11/А шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор өөрчлөн найруулсан/*

9.2 Шүүгчдийн зөвлөгөөнөөр чөлөө авсан тохиолдолд чөлөө авсан өдрөөс эхлэн нэхэмжлэл, гомдол, хүсэлт, хэрэг, даалгаврыг зогсоож, ажилд орох өдрөөс хуанлийн 5 хоногийн өмнөөс эхлэн хуваарилна. */Тус шүүхийн 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 11/А шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор өөрчлөн найруулсан/*

9.3 Шүүгч гэнэтийн тохиолдлоор яаралтай эмчлүүлэх, түүнчлэн эмнэлэгт хэвтсэн тохиолдолд энэ талаар нэн даруй Ерөнхий шүүгч болон танхимын тэргүүнд мэдэгдэх ба энэ журамд заасны дагуу мэдээлэл лавлагааны мэргэжилтэн хэрэг, нэхэмжлэл, хүсэлт, гомдол, даалгавар хуваарилах ажиллагааг системд зогсооно. Энэ тохиолдолд тухайн шүүгч холбогдох баримтыг ирүүлэх бөгөөд ажилд орохын өмнөх ажлын 5 хоногоос эхлэн нэхэмжлэл, гомдол, хүсэлт, хэрэг, даалгаврыг хуваарилна. */Тус шүүхийн 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 11/А шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор өөрчлөн найруулсан/*

9.4 Ээлжийн амралт эхлэхийн өмнөх ажлын 5 өдөрт хэрэг, нэхэмжлэл, даалгавар хуваарилахгүй ба хүсэлтийг ээлжийн амралт эхлэх өдөр хүртэл хуваарилна. Мөн ээлжийн амралт дуусаад ажилдаа орох өдрөөс эхлэн хэрэг, нэхэмжлэл, даалгавар, хүсэлтийг хуваарилна. */Тус шүүхийн 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 11/А шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор өөрчлөн найруулсан/*

III ХЭСЭГ. БУСАД

Аравдугаар зүйл. Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчин төгөлдөр болох, дагаж мөрдөх

10.1 Тус шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор энэхүү журамд нэмэлт, өөрчлөлт оруулна.

10.2 Энэхүү журам нь тус шүүхийн шүүгчдийн зөвлөгөөн хэлэлцэж баталснаар хүчин төгөлдөр болох бөгөөд дагаж мөрдөх, дуусгавар болгох хугацааг шүүгчдийн зөвлөгөөний тогтоолд тусгайлан зааж болно.

**ДҮҮРГИЙН ЭРҮҮ, ИРГЭНИЙ ХЭРГИЙН ХЯЛБАР АЖИЛЛАГААНЫ АНХАН
ШАТНЫ ТОЙРГИЙН ШҮҮХИЙН ШҮҮГЧДИЙН ЗӨВЛӨГӨӨН**